



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/200/СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2022 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn</p> <p>Аудитын менежерийн үүрэг гүйцэтгэгч : Г.Заяа Утас:92038288 Цахим хаяг: zayaq@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Дагвасүрэн Утас:99014227 Цахим хаяг: dagvasurenb@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

2022.02.22 № 1302/МД.

танай _____ -ны № _____ -т

ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ СУМ
ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Б.ӨЛЗИЙ-Д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тосонцэнгэл сумын Сум дундын Шүүхийн Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тосонцэнгэл сумын Сум дундын Шүүхийн Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

013022030

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/мян. Төг/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,658.03</u>	<u>7,296.30</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	7,658.03	7,296.30
354	Хангамжийн материал	7,658.03	7,296.30
35410	Бичиг хэргийн материал	1,060.03	867.70
35420	Аж ахуйн материал	987.60	576.60
35430	Сэлбэг хэрэгсэл	1,905.00	1,890.00
35440	Түлш шатах тослох материал	3,705.30	3,958.50
35450	Барилгын засварын материал		03.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>342,049.90</u>	<u>420,707.01</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>342,049.90</u>	<u>420,707.01</u>
392	Биет хөрөнгө	281,122.90	360,155.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	298,699.40	298,699.40
39202	Хуримтлагдсан элэгдэл	-45,998.40	-51,438.70
39203	Авто-тээврийн хэрэгсэл	76,000.00	138,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-76,000.00	-77,033.30
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	125,152.30	152,659.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-103,287.40	-108,094.60
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,829.50	42,082.04
39208	Хуримтлагдсан элэгдэл	-33,074.90	-35,686.30
39217	Ном	802.30	967.30
393	Биет бус хөрөнгө	60,926.90	60,552.00
39301	Програм хангамж	1,650.00	1,650.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,275.00	-1,650.00
39303	Бусад биет бус хөрөнгө	60,552.00	60,552.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>349,707.90</u>	<u>428,003.30</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>349,707.90</u>	<u>428,003.30</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	349,707.90	428,003.30
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	807,927.80	807,927.80
51101	Өмч: - төрийн	807,927.80	807,927.80
512	Хуримтлагдсан үр дүн	-497,857.60	-419,562.20
51210	Өмнөх үеийн үр дүн	-497,857.60	-497,857.60
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	78,295.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	39,637.80	39,637.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>349,707.90</u>	<u>428,003.30</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/мян. Төг/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	509,183.30	536,037.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,910.50	82,944.50
120	Нийтлэг татварын бус орлого	11,910.50	82,944.50
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	11,399.70	82,641.60
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	11,399.70	82,641.60
120018	Бусад орлого	510.70	302.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	497,272.80	453,093.40
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	497,272.80	453,093.40
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	497,272.80	453,093.40
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	511,142.40	457,742.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	511,142.40	457,742.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	447,528.10	450,258.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	333,378.90	324,036.70
210101	Үндсэн цалин	268,488.70	262,822.60
210102	Нэмэгдэл	38,173.40	33,856.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,941.80	14,874.60
210104	Урамшуулал	11,774.80	12,482.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,568.90	42,787.80
210201	Тэтгэврийн даатгал	29,623.80	29,650.10
210202	Тэтгэмжийн даатгал	3,045.90	3,454.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,488.70	2,599.30
210204	Ажилгүйдлийн даатгал	583.60	621.40
210205	Эрүүл мэндийн даатгал	5,826.60	6,462.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,921.50	11,743.60
210301	Гэрэл, цахилгаан	4,563.50	4,368.60
210302	Түлш, халаалт	7,358.00	7,375.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,161.06	30,754.70
210401	Бичиг хэрэг	7,953.90	8,197.10
210402	Тээвэр, шатахуун	6,422.00	10,546.20
210403	Шүүдан, холбоо, интернэтийн төлбөр	5,960.20	5,846.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	840.00	840.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,984.80	5,325.05
2105	Нормативт зардал	500.00	486.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500.00	486.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,378.30	19,623.70
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,192.20	4,477.20
210604	Урсгал засвар	9,186.06	15,146.50
2107	Томилолт, зочны зардал	3,461.60	2,711.30
210702	Дотоод албан томилолт	3,461.60	2,711.30

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,590.60	3,846.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	594.30	594.30
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	513.00	523.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,361.70	2,361.70
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48.40	63.60
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22.00	22.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс		231.00
210807	Газрын төлбөр	51.20	51.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,567.01	14,267.30
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,567.01	14,267.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,614.30	7,484.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,070.00	1,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,570.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500.00	1,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	47,544.30	6,484.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	47,544.30	6,484.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-1,959.10</u>	<u>78,295.40</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-1,959.10</u>	<u>78,295.40</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	807,927.80	39,637.80	-495,898.50	351,667.07
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	807,927.80	39,637.20	-495,898.50	351,666.40
C06	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,959.10	-1,959.10
C08	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	807,927.80	39,637.80	-497,857.60	349,707.90
D01	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	807,927.80	39,637.80	-497,857.60	349,707.90
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	807,927.80	39,637.80	-497,857.60	349,707.90
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	78,295.40	78,295.40
D09	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	807,927.80	39,637.80	419,562.20	428,003.30

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мян. Төг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	497,272.80	453,093.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	497,272.80	453,093.40
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	497,272.80	453,093.40
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	497,272.80	453,093.40
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	497,272.80	442,810.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	497,272.80	442,810.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	433,658.40	435,326.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	333,378.90	324,036.70
210101	Үндсэн цалин	268,488.70	262,822.60
210102	Нэмэгдэл	38,173.40	33,856.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,941.80	14,874.60
210104	Урамшуулал	11,774.80	12,482.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,568.90	42,787.80
210201	Тэтгэврийн даатгал	29,623.70	29,650.10
210202	Тэтгэмжийн даатгал	3,045.90	3,454.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,488.90	2,599.30
210204	Ажилгүйдлийн даатгал	583.60	621.40
210205	Эрүүл мэндийн даатгал	5,826.60	6,462.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,416.50	13,278.60
210301	Гэрэл, цахилгаан	4,563.50	4,368.60
210302	Түлш, халаалт	8,853.00	8,910.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,873.80	28,552.60
210401	Бичиг хэрэг	6,881.20	7,702.00
210402	Тээвэр, шатахуун	7,156.00	9,264.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,960.20	5,846.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	840.00	840.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,036.40	4,900.00
2105	Нормативт зардал	500.00	500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500.00	500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,867.80	19,612.20
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,681.70	4,462.20
210604	Урсгал засвар	9,186.06	15,150.00
2107	Томилот, зочны зардал	3,461.60	2,711.30
210702	Дотоод албан томилот	3,461.60	2,711.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,590.60	3,846.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	594.30	594.30

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	513.00	523.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,361.70	2,361.70
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48.40	63.60
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22.00	22.00
210807	Газрын төлбөр	51.20	51.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,614.30	7,484.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,070.00	1,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,570.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500.00	1,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	47,544.30	6,484.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	47,544.30	6,484.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	<u>10,282.80</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		10,282.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		10,282.80
2200	Дотоод эх үүсвэрээр		10,282.80
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		10,282.80
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	10,282.80
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мян. Төг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	453,093.40	446,609.00
21	НИЙТ ЗАРЛАГА	453,093.40	446,609.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	452,093.40	445,609.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	324,110.00	324,036.70
210101	Үндсэн цалин	287,966.30	262,822.60
210102	Нэмэгдэл	10,537.80	33,856.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,268.20	14,874.60
210104	Урамшуулал	10,337.70	12,482.50

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,524.20	42,787.80
210201	Тэтгэврийн даатгал	35,346.60	29,650.10
210202	Тэтгэмжийн даатгал	3,294.40	3,454.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,635.50	2,599.30
210204	Ажилгүйдлийн даатгал	658.90	621.40
210205	Эрүүл мэндийн даатгал	6,588.80	6,462.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,661.80	13,278.60
210301	Гэрэл, цахилгаан	4,751.80	4,368.60
210302	Түлш, халаалт	8,910.00	8,910.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,836.80	28,552.60
210401	Бичиг хэрэг	7,702.00	7,702.00
210402	Тээвэр, шатахуун	9,267.00	9,264.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,127.80	5,846.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	840.00	840.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,900.00	4,900.00
2105	Нормативт зардал	500.00	500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500.00	500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,902.50	29,895.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,500.00	11,492.50
210602	Тавилга	3,252.50	3,252.50
210604	Урсгал засвар	15,150.00	15,150.00
2107	Томилолт, зочны зардал	2,711.30	2,711.30
210702	Дотоод албан томилолт	2,711.30	2,711.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,846.80	3,846.80
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	523.00	523.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,361.70	2,361.70
210804	Тээврийн хэрэгслийн татвар	63.60	63.60
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22.00	22.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	231.00	231.00
210807	Газрын төлбөр	51.20	51.20
	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	594.30	594.30
210801	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	594.30	594.30
	Нийгмийн хамгаалал	1000.00	1000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000.00	1,000.00
213209	Сахилга, хариуцлага, ажлын үр дүнгийн урамшуулал	1,000.00	1,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	453,093.40	453,093.40
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	453,093.40	453,093.40
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	453,093.40	453,093.40
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		6,484.30
	Төсвийн бусад мэдээллийн ангилал		
	Байгууллагын тоо	02.00	02.00
	Төсвийн байгууллага	02.00	02.00
	Ажиллагсадын тоо	22.00	22.00

	Удирдах ажилтан	2.00	2.00
	Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00
	Үйлчлэх ажилтан	11.00	11.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Завхан аймгийн осонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын ахлах аудитор Б.Дагвасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежерийн үүрэг гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь Сум дундын Шүүхийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02/05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж дүгнэлээ.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь Сум дундын Шүүхийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 536,037.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,040.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,030.4 мянган сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0	0	0
Бараа материал	7,658.03	7,296.38	-361.65
Үндсэн хөрөнгө	342,049.9	420,707.01	78,657.11
Нийт хөрөнгө	349,707.95	428,003.39	78,295.44
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	349,707.95	428,003.39	78,295.44
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	349,707.95	428,003.39	78,295.44

Бараа материалын дансны үлдэгдэл 361.65 мянган төгрөгөөр буурсан нь аудитын залруулгатай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 78,657.11 мянган төгрөгөөр өссөн нь 62,000.0 мянган төгрөгөөр шинээр автомашин, 20,476.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж Шүүхийн ерөнхий газраас нийлүүлэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 78,295.44 мянган төгрөг болж өссөн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 453,093.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 453,093.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр нийт 453,093.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 446,609.0 мянган төгрөгийг зарцуулж, 6,484.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Төсвийн тухай хууль болон НББ-ийн тухай хууль бусад заавар журмыг дагаж мөрдсөн байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 148 мэдээлэл, хугацаа хоцроосон 1 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар залруулсан, акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй болно.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулга хийгдээгүй болно.